

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/289/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БҮРЭН СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН 2023
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70272248 Цахим хаяг: byambatsogtj@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Релаэнс секюритиз Аудит" ХХК

Утас: 99813174 Цахим хаяг: rsamongolia@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.08.25 № 4/178
танай _____-ны № _____-г

ТӨВ АЙМГИЙН БҮРЭН СУМЫН
ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Б.САЙНБАЯР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бүрэн сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бүрэн сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно. Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 хөтөлбөр 8 арга хэмжээтэй боловсруулан төлөвлөж, 80 хувиар хэрэгжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход

019920426

хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	111,801,898.56	111,268,634.54
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	93,100,483.16	90,451,693.14
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	93,100,483.16	90,451,693.14
3121	Төгрөг	93,100,483.16	90,451,693.14
31211	Төрийн сангийн харилцах	93,100,483.16	90,451,693.14
33	АВЛАГА	00.00	399,408.00
335	Бусад авлага	00.00	399,408.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	00.00	399,408.00
35	БАРАА МАТЕРИАЛ	18,701,415.40	20,417,533.40
354	Хангамжийн материал	18,701,415.40	20,417,533.40
35410	Бичиг хэргийн материал	100,550.00	00.00
35420	Аж ахуйн материал	4,351,925.40	3,346,233.40
35460	Хүнсний материал	1,909,500.00	2,099,900.00
35470	Бусад хангамжийн материал	12,339,440.00	14,971,400.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	641,962,145.01	620,242,318.52
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	641,962,145.01	620,242,318.52
392	Биет хөрөнгө	597,638,145.01	575,918,318.52
39201	Барилга, байгууламж, орон сууц	653,666,651.53	653,666,651.53
39202	Хуримтлагдсан элэгдэл	-95,258,321.74	-115,189,275.54
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	35,285,510.00	34,331,510.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-13,072,771.65	-14,288,985.52
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	41,828,924.90	44,691,924.90
39208	Хуримтлагдсан элэгдэл	-29,223,848.03	-31,947,256.85
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,110,000.00	4,660,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-411,000.00	-719,250.00
39217	Ном	713,000.00	713,000.00
393	Биет бус хөрөнгө	44,324,000.00	44,324,000.00
39301	Програм хангамж	100,000.00	100,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-100,000.00	-100,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	44,324,000.00	44,324,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	753,764,043.57	731,510,953.06
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	753,764,043.57	731,510,953.06
51	Засгийн газрын хувь оролцоо	753,764,043.57	731,510,953.06
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	550,953,903.00	550,953,903.00
51101	Өмч: - төрийн	550,953,903.00	550,953,903.00
512	Хуримтлагдсан үр дүн	-10,144,573.76	-32,397,664.27
51210	Өмнөх үеийн үр дүн	-10,144,573.76	-10,144,573.76
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-22,253,090.51
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	212,954,714.33	212,954,714.33
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	753,764,043.57	731,510,953.06

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,131,877,177.09	435,091,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	689,695,177.09	3,362,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	689,695,177.09	3,362,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	689,695,177.09	3,362,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	689,695,177.09	3,362,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	442,182,000.00	431,729,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	175,998,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	175,998,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,526,300.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,526,300.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	52,940,700.00	43,132,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт торон нутгийн төсөвт байрлалд	52,940,700.00	43,132,600.00
1330	Төсвийн захирагчдаас	374,715,000.00	212,598,600.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	374,715,000.00	212,598,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	380,394,886.04	456,569,969.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	380,394,886.04	456,569,969.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	361,643,208.42	456,569,969.87
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	211,379,897.04	277,144,812.22
210101	Үндсэн цалин	172,807,206.93	214,379,197.58
210102	Нэмэгдэл	26,790,632.97	51,639,784.04
210104	Урамшуулал	11,782,057.14	11,125,830.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,545,913.80	34,616,242.44
210201	Тэтгэврийн даатгал	17,223,760.24	24,336,509.03
210202	Тэтгэмжийн даатгал	2,081,278.45	2,793,448.23
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,665,022.58	2,217,158.61
210204	Ажилгүйдлийн даатгал	413,295.76	476,970.43
210205	Эрүүл мэндийн даатгал	4,162,556.77	4,792,156.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,261,445.92	40,854,507.36
210301	Гэрэл, цахилгаан	3,891,331.92	3,505,815.26
210302	Түлш, халаалт	23,886,664.00	35,026,240.10
210303	Цэвэр, бохир ус	483,450.00	2,322,452.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,849,110.00	3,552,532.00
210401	Бичиг хэрэг	00.00	66,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,335,950.00	2,146,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	1,340,132.00
210408	Бараа материал акталсны зардал	513,160.00	00.00
2105	Нормативт зардал	52,035,240.00	58,066,120.00
210502	Хоол, хүнс	52,035,240.00	58,066,120.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	495,540.00	885,000.00
210604	Урсгал засвар	495,540.00	885,000.00
2107	Томилолт, зочны зардал	28,000.00	426,000.00
210702	Дотоод албан томилолт	28,000.00	426,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	299,900.00	720,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	299,900.00	720,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41,748,161.66	40,304,755.85
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,782,080.00	7,029,850.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,950,330.00	1,047,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	33,015,751.66	32,227,505.85
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,751,677.62	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,422,800.00	00.00

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	442,182,000.00	431,729,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	442,182,000.00	431,729,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	175,998,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	175,998,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,526,300.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,526,300.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	52,940,700.00	43,132,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	52,940,700.00	43,132,600.00
1330	Төсвийн захирагчдаас	374,715,000.00	212,598,600.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	374,715,000.00	212,598,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	349,081,516.84	426,457,990.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	349,081,516.84	426,457,990.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	330,329,839.22	426,457,990.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	210,324,800.03	277,430,687.02
210101	Үндсэн цалин	171,752,109.96	215,680,813.98
210102	Нэмэгдэл	26,790,632.97	50,824,042.44
210104	Урамшуулал	11,782,057.10	10,925,830.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,023,593.27	34,729,775.64
210201	Тэтгэврийн даатгал	16,575,656.97	24,266,547.67
210202	Тэтгэмжийн даатгал	1,862,493.52	2,760,817.75
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,489,998.61	2,208,594.22
210204	Ажилгүйдлийн даатгал	370,468.60	492,741.54
210205	Эрүүл мэндийн даатгал	3,724,975.57	5,001,074.46
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,261,445.92	40,854,507.36
210301	Гэрэл, цахилгаан	3,834,237.00	3,505,815.26
210302	Түлш, халаалт	23,293,308.92	35,026,240.10
210303	Цэвэр, бохир ус	1,133,900.00	2,322,452.00
2104	Хангамж, бараа материалын зардал	103,500.00	00.00
210401	Бичиг хэрэг	103,500.00	00.00
2105	Нормативт зардал	50,578,750.00	58,256,520.00
210502	Хоол, хүнс	50,578,750.00	58,256,520.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,495,540.00	500,000.00
210604	Урсгал засвар	4,495,540.00	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	389,900.00	820,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	389,900.00	820,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,152,310.00	13,866,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,902,550.00	12,288,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,249,760.00	1,577,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,751,677.62	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,422,800.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	14,422,800.00	00.00

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,328,877.62	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,328,877.62	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	93,100,483.16	5,271,209.98
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	7,920,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	7,920,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	7,920,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	7,920,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-7,920,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	93,100,483.16	-2,648,790.02
9	Мөнгө, түүнтэй адилтах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	93,100,483.16
10	Мөнгө, түүнтэй адилтах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	93,100,483.16	90,451,693.14

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	550,953,903.00	232,924,744.72	-31,790,858.59	752,087,789.13
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	550,953,903.00	232,924,744.72	-31,790,858.59	752,087,789.13
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-8,430,671.10	-8,430,671.10
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	550,953,903.00	212,954,714.33	-10,144,573.76	753,764,043.57
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	550,953,903.00	212,954,714.33	-10,144,573.76	753,764,043.57
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	550,953,903.00	212,954,714.33	-10,144,573.76	753,764,043.57
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-22,253,090.51	-22,253,090.51
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	550,953,903.00	212,954,714.33	-32,397,664.27	731,510,953.06

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
1	Мөнгө, түүнтэй адилтах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	434,378,690.02	392,960,482.66	-41,418,207.36	90.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	434,378,690.02	392,960,482.66	-41,418,207.36	90.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	434,378,690.02	392,960,482.66	-41,418,207.36	90.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	277,430,687.02	277,430,687.02	00.00	100.0
210101	Үндсэн цалин	215,680,813.98	215,680,813.98	00.00	100.0
210102	Нэмэгдэл	50,824,042.44	50,824,042.44	00.00	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,691,524.80	00.00	-4,691,524.80	0.0
210104	Урамшуулал	6,234,305.80	10,925,830.60	4,691,524.80	175.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,729,775.64	34,729,775.64	00.00	100.0
210201	Тэтгэврийн даатгал	24,266,547.67	24,266,547.67	00.00	100.0

210202	Тэтгэмжийн даатгал	2,760,817.75	2,760,817.75	00.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,208,594.22	2,208,594.22	00.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	492,741.54	492,741.54	00.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	5,001,074.46	5,001,074.46	00.00	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,854,507.36	00.00	-40,854,507.36	0.0
210301	Гэрэл, цахилгаан	3,505,815.26	00.00	-3,505,815.26	0.0
210302	Түлш, халаалт	35,026,240.10	00.00	-35,026,240.10	0.0
210303	Цэвэр, бохир ус	2,322,452.00	00.00	-2,322,452.00	0.0
2105	Нормативт зардал	58,256,520.00	58,340,020.00	83,500.00	100.1
210502	Хоол, хүнс	58,256,520.00	58,340,020.00	83,500.00	100.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	00.00	-500,000.00	0.0
210604	Урсгал засвар	500,000.00	00.00	-500,000.00	0.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлб	820,000.00	820,000.00	00.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	820,000.00	820,000.00	00.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21787200.00	21640000.00	-147,200.00	99.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,029,500.00	18,882,300.00	-147,200.00	99.2
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,757,700.00	2,757,700.00	00.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	442,730,200.00	388,596,600.00	-54,133,600.00	87.8
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	399,597,600.00	388,596,600.00	-11,001,000.00	97.2
131001	Улсын төсвөөс санхүүжих	399,597,600.00	388,596,600.00	-11,001,000.00	97.2
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	43,132,600.00	00.00	-43,132,600.00	0.0
132001	Орон нутгийн төсвөөс	43,132,600.00	00.00	-43,132,600.00	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	93,100,483.16	93,100,483.16	#DIV/0!
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	93,100,483.16	93,100,483.16	#DIV/0!
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	21.00	21.00	00.00	100.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	00.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	12.00	12.00	00.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	08.00	08.00	00.00	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Бүрэн сумын Хүүхдийн цэцэрлэг нь сургуулийн өмнөх насны хүүхдийг бие бялдар оюун ухаан нийгэмшихүй хөгжлийг хангах чиг үүргийг хэрэгжүүлдэг Боловсрол шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Төв аймгийн Бүрэн сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2023 оныг "Залуучуудын хөгжлийг дэмжих" жил болгон зарлаж, дэвшүүлсэн зорилго, зорилтын хүрээнд байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 зорилт, 8 арга хэмжээтэйгээр боловсруулан хэрэгжүүлж, төлөвлөгөөг 90,5 хувиар биелүүлж ажилласан байна.

Тус цэцэрлэг нь 21 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Боловсролын тухай хууль
- Төсвийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил гүйлгээ худалдан авах тухай хууль,
- Шилэн дансны тухай хууль,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжууд мөн Сангийн яам болон харьяа эрүүл мэндийн яамнаас гаргасан тушаал,заавар журам шийдвэрүүдийг мөрдөж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт *ороогүй* байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

2023 он 11 сард аймгийн засаг даргын нэрэмжит үзлэг шалгалт хамрагдсан. 95,0 хувьтай үнэлэгдсэн.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Бүрэн сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Бүрэн сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 22,253.1 мянган төгрөгөөр буюу 2,9 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	93,100.5	90,451.7	3,351.2
Авлага		399.4	399.4
Урьдчилгаа			
Бараа материал	18,701.4	20,417.5	1,716.1
Үндсэн хөрөнгө	641,962.1	620,242.3	21,719.8
Нийт хөрөнгө	753,764.0	731,510.9	22,253.1
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	753,764.0	731,510.9	22,253.1
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	753,764.0	731,510.9	22,253.1

/мянган төгрөгөөр/

Дээрх хүснэгтээс харахад 2023 оны жилийн эцэст мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 3,351.2 мянган төгрөгөөр хорогдсон нь орон тоо дутуу ажилласан, үндсэн, урамшуулал, нэмэгдэл цалин болон хэмнэснээс шалтгаалан мөнгө данс өссөн байна.

Авлага дансны үлдэгдэл 399.4 мянган төгрөг нь нийгмийн даатгалын байгууллагын шалгалтаар тавигдсан өр юм.

Бараа материал дансны үлдэгдэл 1,716,1 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуй, хүнсний болон хангамжийн материалуудыг нөөцлөн авсантай холбоотой.

Үндсэн хөрөнгийн данс 21,719.8 мянган төгрөгөөр өссөн нь Улсын төсвийн хөрөнгөөр 7,920.0 мянган төгрөгөөр машин тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл худалдан авсан. Хандиваар нийт 2,330.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, бусад үндсэн хөрөнгө авсан.

Бүрэн сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 19-ны 04 дүгээр тогтоолоор Хүүхдийн цэцэрлэгийн 24 нэр төрлийн нийт 18,900.0 мянган төгрөгийн хөрөнгийг акталсан зэргээс шалтгаалан үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 391,246.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 43,132.0 мянган төгрөг зарлагыг нийт 434,378.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг 434,378.6 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 434,378.6 мянган төгрөгөөр тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 391,246.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 392,960.4 мянган төгрөг буюу 90,5 хувьтай байгаа нь тодотгосон гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 41,418.2 мянган төгрөгөөр, үүнээс байр ашиглалттайхолбоотой зардлыг 40,854.5 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний зардлыг 147.2 мянган төгрөгөөр урсгал засварыг 500.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

Орон нутгийн төсвөөс 43,132.0 мянган төгрөгийн тогтмол зардлыг санхүүжүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	71801-Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	81605-Эрүүл мэндийг дэмжих	1,379.7	1,354.2	25.5	98%
2	81807-Цэцэрлэгийн хүүхдийн хоол	65,919.8	55,177.9	10,741.9	83,7%
3	81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	4,466.4	4,466.4	0	100%
4	81823-Багш ажилтны мэргэжил дээшлүүлэх	1,379.7	1,379,0	0.7	99,9%

5	81832 Нүүдлийн бүлэгт хамруулах	27,729.1	24,119.7	3,609.4	86,9%
6	81834 Боловсролын стандарт	282,032.1	247,315.7	34,716.4	87,6%
7	81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	109,790.7	59,210.6	50,580.1	53,9%
8	80111 Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	43,132.6	41,354.5	1,778.9	95,8%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Бүрэн сумын хүүхдийн цэцэрлэг нь нэмэлт санхүүжилтийн төсөв байхгүй.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	71801-81605	2023-12-31	Эрүүл мэндийг дэмжих	98%	1,379.7	1,354.2
2	71801-81807	2023-12-31	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	83,7%	65,919.8	55,177.9
3	71801-81816	2023-12-31	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	100%	4,466.4	4,466.4
4	71801-81823	2023-12-31	Багш ажилтны мэргэжил дээшлүүлэх	99,9%	1,379.7	1,379.0
5	71801-81832	2023-12-31	Нүүдлийн бүлэгт хамруулах	86,9%	27,729.1	24,119.7
6	71801-81834	2023-12-31	Боловсролын стандарт	87,6%	282,032.1	247,315.7
7	71801-81835	2023-12-31	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	53,9%	59,210.6	50,580.1
8	71801-80111	2023-12-31	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	95,8%	43,132.6	41,354.5

Цэцэрлэгийн хүүхдийн хоол арга хэмжээ нь дутуу хэрэгжсэн нь сургуулийн хүүхдийн улирлын амралттай холбоотойгоор хүүхдийн ирц багасдагтай холбоотойгоор хэмнэгдсэн.

Нүүдлийн бүлэгт хамруулах арга хэмжээ нь дутуу хэрэгжсэн нь орон тоо хэмнэсэн, хүүхдийн ирцтэй холбоотойгоор хэмнэгдсэн.

Сургалтын хэвийн үйл ажиллагаа арга хэмжээ нь дутуу хэрэгжсэн нь томуу томуу тест өвчин ихэссэн, ЕБС цахимд шилжсэнтэй холбоотойгоор хүүхдийн ирц буурсан..

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Бүрэн сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2023 онд цахим дэлгүүрээс 15,000.0 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн байна. Төв аймгийн Бүрэн сумын төсвийн ерөнхийлөн захирагч, захирагчийн худалдан авах ажиллагааны хүрээнд хийгдсэн байна. Үүнд: Цахим дэлгүүрт сүүлийн үеийн тоног, төхөөрөмжийн өргөн сонголт байхгүй байсан тул PC mall –оос худалдан авалт хийсэн байна

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Бүрэн сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах ажиллагчидтай холбоотой авлагыг барагдуулах, дансны үлдэгдлийг улирал, жилийн санхүүгийн эцэст баталгаажуулж байхтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Релаэнс секюритиз аудит ХХК-ийн ахлах аудитор Б.Мягмар, аудитор С.Дашдондог нар гүйцэтгэж, хяналтыг Релаэнс секюритиз аудит ХХК-ийн захирал, аудитор Ж.Цэцэгмаа, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт, аудитын менежер О.Амаржаргал, дарга, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Бүрэн сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2024 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 32 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 345,000.0 мянган төгрөгөөс 2,0 хувиар буюу 6,900.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 5,520.0 мянган төгрөгөөр тооцлоо. Аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага 3 заалт бүхий төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажилласны үр дүнд ажиллагсад олгох цалин хөлстэй холбоотой орон тоог хэмнэж ажиллах, төлөвлөгдсөн бараа ажил үйлчилгээний зардлыг төлөвлөгөөт хэмжээнд нь зарцуулах буюу хэмнэх зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

Төв аймгийн Бүрэн сумын цэцэрлэг нь 2023 онд батлагдсан төсвийг үр бүтээлтэй хэрэгжүүлэх 8 төрлийн арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан ажилласан байна. 2023 оны төсвийг хэмнэж үр бүтээлтэй ажиллах, тогтмол зардал болон эд хогшил худалдан авах зардлыг хэмнэх арга хэмжээ авснаар доорхи хэмнэлт гаргасан байна. Үүнд:

- Байр ашиглахтай холбоотой болон эд хогшил худалдан авах зардлыг 40,854.5 мянган төгрөгөөр
- Хангамжийн бараа материал болон бусдаар гүйцэтгэх ажил үйлчилгээний зардлыг 647.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хөтлөлтийг шалгахад Төв аймгийн Бүрэн сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2023 онд 159 мэдээллийг шилэн дансанд байршуулахаас 148 мэдээллийг байршуулж 11 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан. Энэ нь шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.1-д “Мэдээлэл үнэн зөв бодитой иж бүрэн байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх”, 6.4.4-д “Таван саяаас дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил гүйлгээ”, МУЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 7 дугаар зүйлийн 7.5.3 “өөрийн хянах цэсийн мэдээллийг байнга хянах” заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Цаашид шилэн дансны хуулийг хэрэгжүүлэхдээ нэг ч мэдээлэл хоцруулахгүй байхыг анхааруулан зөвлөмж өглөө .

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Бүрэн сумын Хүүхдийн цэцэрлэг нь эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн. Завсрын аудитын явцад асуудлын бүртгэлээр 3 зөвлөмж өгөгдсөн ба биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад 2 зөвлөмжийг залруулсан ба 1 зөвлөмж хэрэгжээгүй тул аудитын тайланд тусган зөрчлөөр оруулсан болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	382,4	1	382,4	100
Албан шаардлага	3	26,975,8	3	26,975,8	100
Зөвлөмж	1	1,384,2	1	1,384,2	100
Нийт дүн	5	28,742,4	5	28,742,4	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Санхүүгийн тайланг хугацаанд нь үнэн зөв гаргаж байхыг анхааруулав

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 9,416.1 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 8,885.0 мянган төгрөгийн алдааг залруулж 531.1 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоов.

2023 онд 8,885.0 мянган төгрөгийн барилга байгууламжийн урсгал засварын зардал нь хийж гүйцэтгэсэн ажлын анхан шатны орлого, зарлагын баримт дутуу байсан. Энэ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалт Санхүүгийн тайлангийн “Иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

5.1 Төлбөрийн акт

1. Хүүхдийн хоолны орц нормыг баримтлан ажиллаагүйгээс 531.1 мянган төгрөгийн хүнсний материалыг илүү зарцуулсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д “Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, Боловсрол шинжлэх ухааны яамны сайд, Эрүүл мэндийн яамны сайд, Сангийн яамны сайдын 2020 оны 12 дугаар сарын 02-ний өдрийн А/166,А/222,599 дугаартай хамтарсан тушаалыг дагаж мөрдөөгүй, Санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх төлбөрийн акт тогтоох журмын 4.2.3.6-т "Эрх бүхий этгээдээс тогтоосон норм нормативыг хэтрүүлэн зарцуулсан" гэж заасныг үндэслэн 531.1 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоов.

Дээрх төлбөрийн актын биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Анхан шатны баримтын бүрдэлгүй урсгал засварын зардал	1	8,885.0					1	8,885.0				
Дүн		8,885.0					1	8,885.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хүүхдийн хоолны орц нормыг хэрэгжүүлэн ажиллаагүй	1	531.1	1	531.1								
Дүн	1	531.1	1	531.1								

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд байршуулах 11 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан	1						1	
Дүн	1						1	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn